ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2026 оны 11 сарын 11 өдөр Дугаар 19/03 Арвайхээр сум

Хөрөнгө акталж, данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 24/02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон Хужирт сумын 2 дугаар цэцэрлэг, Хужирт сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, энэхүү тогтоолын хавсралтад заасан нийт 9,436,669.84 (есөн сая дөрвөн зуун гучин зургаан мянга зургаан зургаан зуун жаран есөн төгрөг наян дөрөв) төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй барилгуудыг акталж, данснаас хассугай.

2.Хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулан хөрөнгийн хөдлөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системээс хасах ажлыг зохион байгуулж, барилга актлахтай холбогдуулан барилгыг буулгах, газрыг чөлөөлөхөд хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмыг ханган биелүүлж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

ДАРГА Т.НАРАНГАРАВ

ИТХ/nuuts2026/1.togtool/togtool.doc

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 11 дүгээр сарын 11 -ний өдрийн
19/03 дугаар тогтоолын хавсралт

АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл
1	Хужирт сумын 2 дугаар цэцэрлэг	Склад	1972.01.01	м2	12	588,000.0	588,000.0
Дүн						**588,000.0**	**588,000.0**
2	Хужирт сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	Хүнсний склад	1958.01.09	м2	180	4,725,000.0	4,725,000.0
		Склад	1952.01.01	м2	20	4,123,669.84	4,123,669.84
Дүн						**8,848,669.8**	**8,848,669.8**
Нийт дүн						**9,436,669.84**	**9,436,669.84**

___oOo___